

## **Аудитын түүврийн хэмжээнд нөлөөлөх хүчин зүйлс**

### **Factors Affecting the Audit Sample Size**

Н. Дамдиндорж<sup>1</sup>, Э. Ундармаа<sup>2</sup>

#### **Хураангуй**

Аудитор аудитыг гүйцэтгэхдээ хязгаарлагдмал хугацаанд, бага зардлаар, үр ашигтай гүйцэтгэхийг зорьдог бөгөөд эдгээр зорилгодоо хүрэхийн тулд аудитын олон төрлийн горимуудыг хослуулан ашигладаг. Эдгээр горимуудын нэг нь аудитын түүвэрлэлт бөгөөд түүврийг хэр үр дүнтэй, үндэслэлтэй хийсэн эсэхээс хамааран аудитын ажлын үр дүнд шууд нөлөө үзүүлэх боломжтой юм. Тиймээс аудиторуд түүврийн хэмжээг хэр ул үндэслэлтэй тогтоосон болон түүвэр хийх аргыг хэр зохимжтой сонгосон нь аудитын ажлыг чанарт нөлөөлж байна. Бид энэхүү судалгааны ажлаараа түүврийн хэмжээг тогтооход нөлөөлөх хүчин зүйлсийг илэрүүлж, тэдгээр хүчин зүйлс нь түүврийн хэмжээнд хэрхэн нөлөөлж болохыг илэрүүлэхийг зорьсон болно.

*Түлхүүр үгс:* түүвэр, хүчин зүйлс, нөлөөлөл

#### **Abstract**

Auditors aim to perform audits in a limited time, at low cost, and efficiently, and to achieve these goals, they use a combination of various audit procedures. One of these procedures is audit sampling, which can directly affect the results of the audit, depending on how effectively and reasonably the sampling is carried out. Therefore, how reasonably the auditors determine the sample size and how appropriately the sampling method is chosen affects the quality of the audit. In this research, we aim to identify the factors that influence sample size and how those factors can affect sample size.

*Keywords:* sample, factors, influence

---

<sup>1</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим  
E-mail: damdindorj.n@num.edu.mn

<sup>1</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим  
E-mail: undarmaa.e@num.edu.mn

### Аудитын түүврийн тухай ойлголт

АОУС 530-д аудитын түүвэрлэлт гэдэг нь “тухайн эх олонлогийн талаар дүгнэлт гаргах ул үндэслэлтэй нотолгоогоор аудиторыг хангахын тулд түүвэрлэлтийн бүх нэгжүүд сонгогдох магадлалтай байхаар аудитын холбогдолтой эх олонлогын зүйлсийн 100-аас доош хувьд аудитын горимуудыг ашиглах явдал юм” гэж тодорхойлжээ. Тиймээс аудитор шалгаж байгаа зүйлсээс тодорхой шалгуурд нийцсэн зүйлсийг сонгон авч шалгалтыг гүйцэтгээд, сонгогдсон болон бусад сонгогдоогүй зүйлсийн талаар тохиромжтой санал дүгнэлт өгөхийг хэлдэг. Аудитор аудитыг гүйцэтгэхдээ гэрээний хязгаарлагдмал хугацаанд аль болох бага зардлаар гүйцэтгэхийг зорьдог бөгөөд энэ зорилгод нийцэх аудитын горим нь түүвэрлэлт байдаг. Аудитын түүвэрлэлтэд дараах үндсэн ойлголтууд байдаг. Үүнд:

- Эх олонлог – Энэ нь бүтэн багц мэдээлэл бөгөөд аудитор уг мэдээллээс түүвэр хийн сонгон авч, түүний талаар дүгнэлт гаргахыг зорьдог.
- Түүврийн олонлог – Эх олонлогоос тохиромжтой аргаар шалгуур хангасан мэдээллийг сонгон авсан багц мэдээллийг хэлнэ.
- Түүврийн нэгж – Олонлогыг бүрдүүлж байгаа мэдээллийн суурь үзүүлэлт бөгөөд аудитад мөнгөн нэгж эсвэл тоон нэгж гэж байна.
- Үечлэл – Олонлогыг тус бүрдээ ижил шинж бүхий түүврийн нэгжүүдийн бүлэг байх дэд олонлогуудад хуваах үйл явц юм.
- Түүврийн эрсдэл – Олонлогыг бүхэлд нь аудитын ижил горимоор шалгахад хүрэх байсан дүгнэлтээс түүвэрт үндэслэн гаргасан аудиторын

дүгнэлт нь ялгаатай байх нөхцөлд түүвэрлэлтийн эрсдэл үүсдэг.

- Түүврийн бус эрсдэл – Түүвэрлэлтийн эрсдэлтэй холбоогүй аливаа шалтгаанаар аудитор алдаатай дүгнэлт гаргахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл аудитын горимуудыг зохисгүйгээр хэрэглэх эсвэл аудитын нотологоог буруугаар тайлбарлах болон алдаатай тайлагнал, хэлбэлзлийг хүлээн зөвшөөрөхгүй байх зэрэг болно.
- Хэвийн бус алдаа – Эх олонлог дахь алдаатай тайлагнал эсвэл хэлбэлзлийг үл төлөөлөх алдаатай тайлагнал, эсвэл хэлбэлзэл.
- Тэвчиж болох алдаатай тайлагнал – Аудитор нь мөнгөн дүнг олонлогийн хувьд бодит алдаанаас хэтрүүлэхгүй бөгөөд энэ мөнгөн дүн нь хүлээн зөвшөөрөгдөх түвшингээс хэтрэхгүй байхыг хэлнэ.
- Тэвчиж болох хэлбэлзлийн түвшин – Аудиторын дотоод хяналтын горимоор тогтоосон хэлбэлзлийн түвшин нь хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байх бөгөөд энэ хэлбэлзлийн түвшин нь олонлогийн бодит хэлбэлзлийн түвшнээс хэтрэхгүй байхыг хэлнэ.

Аудитын түүвэрлэлтийн дараагийн чухал ойлголт нь эх олонлогоос түүвэрийг сонгож авах арга бөгөөд түүвэрлэлт нь тухайн түүврийг сонгон авсан эх олонлогийн талаар дүгнэлт гаргахад нь аудиторыг хангалттай ба зохистой нотолгоогоор хангах зорилготой учираас аудитор уг эх олонлогийн нийтлэг шинжийг агуулсан зүйлсийг түүвэрт авах замаар төлөөлөхүйц түүврийг сонгох нь чухал юм. Аудитор түүврийн зүйлийг сонгохдоо мэргэжлийн шийдэл буюу өөрийн мэдлэг, туршлага, ур чадвартаа үндэслэсэн бол статистик

бус түүвэр харин түүврийн нэгж бүрийг сонгогдох магадлалтайгаар түүврийн гүйцэтгэсэн бол статистик түүвэрлэлт гэнэ. Статистик түүврийн аргад дараах аргууд байна (Хүснэгт 1).

Дээрх аргуудын сонголт нь мэдээж аудиторын тухайн эх олонлогийн шинж байдалд тохируулан ганцаарчлан эсвэл хослуулан хэрэглэх боломжтой юм.

Аудитын түүврийн хэмжээнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох нь

Аудиторуудын хувьд түүврийг гүйцэтгэхэд хамгийн гол асуудлуудын нэг нь түүврийн хэмжээ байдаг бөгөөд уг түүврийн хэмжээг тогтооход харгалзан үзэх хүчин зүйлсийг тодорхойлохыг оролдлоо. Түүврийн хэмжээ нь их байвал эх олонлогийг төлөөлж чадах боломж өсөх боловч

хязгаарлагч хүчин зүйл нь хугацаа болон зардлын үр ашигтай байдал байх юм. Тиймээс аудиторууд тохиромжтой хугацаанд, үр ашигтай зардлаар аудитын горимыг гүйцэтгэж болох түүврийн хэмжээг тогтоохыг зорьдог. Бидний судалснаар дараах хүчин зүйлс түүврийн хэмжээнд нөлөөлж болох бөгөөд түүврийн хэмжээнд хэрхэн нөлөөлөх нөлөөллийг мөн тогтоохыг зорьсон (Хүснэгт 2).

Эдгээр хүчин зүйлс нь шалгагдаж байгаа эх олонлогоос түүвэрлэн авах олонлогын хэмжээнд нөлөө үзүүлнэ гэж тогтоосон бөгөөд харин эдгээр хүчин зүйлс нь хэрхэн нөлөөлөхийг Хүснэгт 3-т харууллаа.

Дээрх тодорхойлсон хүчин зүйлс болон түүврийн хэмжээнд нөлөөлөх нөлөөллийг аудиторууд хослосон байдлаар нөлөөллийг

Хүснэгт 1. Түүврийн сонгох арга

| № | Түүврийн арга          | Агуулга  |
|---|------------------------|--|
| 1 | Санамсаргүй сонголт    | Санамсаргүйгээр тоо үүсгэх эсвэл санамсаргүйгээр тоон хүснэгт үүсгэн ашиглана.   |
| 2 | Системтэй сонголт      | Олонлог дахь түүврийн нэгжийн тоог түүврийн хэмжээнд хуваан түүвэрлэлтийн интервалыг олж, сонгох түүврийн нэгж бүр нь уг интервалаар өсч сонгогдоно. |
| 3 | Мөнгөн нэгжийн сонголт | Эх олонлогоос тогтоосон мөнгөн дүнг давсан нэгжийг сонгох бөгөөд энэ арга нь зарим тохиолдолд аудитад үр дүнтэй байж болно.                          |
| 4 | Бүлгийн сонголт        | Эх олонлогоос зэрэгцээ зүйлсийн бүлгийг сонгох ба аудитад тэр бүр нийтлэг ашигладаггүй.  |

Эх сурвалж: Аудитын Олон Улсын стандарт, 2018

Хүснэгт 2. Түүврийн хэмжээнд нөлөөлөх хүчин зүйлс

| № | Хүчин зүйлсийн нэр  | Агуулга   |
|---|---|---|
| 1 | Аудитын эрсдэл  | Санхүүгийн тайлан материаллаг хэмжээгээр буруу илэрхийлэгдсэн үед аудитор тохиромжгүй дүгнэлт санал өгөхийг хэлдэг. |
| 2 | Материаллагын түвшин буюу тэвчиж болох алдаатай тайлагнал | Санхүүгийн тайлан дахь буруу илэрхийллийн хамгийн бага хэмжээ буюу мөнгөн дүнг хэлнэ.                               |
| 3 | Тэвчиж болох хэлбэлзэл                                    | Тогтоосон хэлбэлзлийн түвшин нь бодит хэлбэлзлийн түвшнээс хэтрэхгүй байхыг хэлнэ                                   |
| 4 | Олонлогын хэмжээ  | Шалгаж байгаа багц мэдээлэл буюу ажил гүйлгээ. Олонлогыг мөнгөн болон тоон нэгжээр илэрхийлдэг.                     |
| 5 | Аудитын нарийвчилсан горимын хэрэглээ                     | Тухайн батламж мэдэгдлийн хүрээнд сонгогдсон дансанд биечлэн гүйцэтгэх горимыг хэлдэг.                              |

Эх сурвалж: Судлаачдын судалгаа

## Хүснэгт 3. Хүчин зүйлс болон түүврийн хэмжээний хамаарал

| № | Хүчин зүйлсийн нэр  | Хамаарал         | Тайлбар  |
|---|---|------------------|--|
| 1 | Аудитын эрсдэл  | Шууд             | Аудитын эрсдэлийг их гэж үнэлсэн бол эрсдлийг боломжит түвшин хүртэл бууруулахын тулд түүврийн хэмжээг өсгөн.  |
| 2 | Материаллагын түвшин буюу тэвчиж болох алдаатай тайлагнал | Урвуу            | Материаллагын түвшинг өндөр тогтоосон бол аудитор алдаанд тооцох мөнгөн дүн их байгаа учир түүврийн хэмжээг багаар тогтооно.   |
| 3 | Тэвчиж болох хэлбэлзэл                                    | Урвуу            | Эх олонлог болон түүврийн олонлогийн хоорондох зөрүүтэй байдлын хүлээн зөвшөөрөгдөх хэмжээ бага байх тутам түүврийн хэмжээ их байна.   |
| 4 | Олонлогын хэмжээ  | Нөлөөлөл багатай | Гэхдээ зарим үед бага хэмжээтэй эх олонлогийн хувьд бүгдийг сонгох эсвэл их хэмжээтэй эх олонлогын хувьд тогтоосон түүврийн хэмжээ нь өмнөхтэй харьцуулахад бага байж болно. |
| 5 | Аудитын нарийвчилсан горимын хэрэглээ                     | Урвуу            | Хэрэв зарим данс буюу эх олонлогийн хувьд түүврээс бусад нарийвчилсан горимын хэрэглээ өсөх бол түүврийн хэмжээ бага байна.  |

*Эх сурвалж: Судлаачдын судалгаа*

харгалзан үзэж эцсийн түүврийн хэмжээг тодорхойлох нь зүйтэй юм. Зарим хүчин зүйлс нь шууд хамааралтай байгаа бол зарим нь урвуу хамааралтай байгаа бөгөөд эдгээр нөлөөлийг харгалзан үзэж, аудиторын мэргэжлийн шийдлээр эцсийн үр дүнгээ тогтоож байх нь зохимжтой юм.

#### Дүгнэлт

Түүвэрлэлт нь аудитад түгээмэл хэрэглэдэг горим бөгөөд практикт түүврийн хэмжээг тохиромжтой тогтоох нь гол асуудлуудын нэг байна. Тиймээс түүврийн хэмжээг тогтооход нөлөөлдөг хүчин зүйлсийн тодорхойлж, тэдгээрийн нөлөөллийг илэрүүлэхийг уг судалгааны ажлын үндсэн зорилго байсан. Бид судалгааны ажлаараа

дээрх тавьсан зорилгоодоо хүрч, түүврийн хэмжээг тогтооход нөлөөлж болох 5 хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрийн түүврийн хэмжээнд хэрхэн нөлөөлөх боломжит хамаарлыг мөн тодорхойлсон болно. Гэхдээ хүчин зүйлсүүдийн нөлөөллийг тус тусад харгалзан үзэж эцсийн үр дүнг тухайн нөхцөлд аудиторын мэргэжлийн шийдлээр гаргахыг зөвлөж байна.

Дараагийн судлаачдын хувьд тодорхойлсон хүчин зүйлс болон нөлөөллийг харгалзан үзэж түүврийн хэмжээг оновчлох асуудлыг судалгааны чиглэлээ болговол сонирхолтой бөгөөд практик ач холбогдолтой байх болно.

## Ашигласан материал

- Abdul-Hamid, M. A., Mohamed, S., & Md-Nassir, A. (1996). Sampling Size and Auditor's Judgement: A Simulation. *Pertanika Journal of Social Sciences and Humanities*, 4(2), 175-184.
- Canadian Audit and Accountability Foundation (2021). *Sampling Methodology for Performance Audits*. Ontario.
- Heimann, S. R., & Chesley, G. R. (1977). Audit Sample Sizes for Aggregated Statement Accounts. *Journal of Accounting Research*, 15(2), 193-206.  
<https://doi.org/10.2307/2490348>
- Kachelmeier, S. J., & Messier, W. F., Jr. (1990). An Investigation of the Influence of a Nonstatistical Decision Aid on Auditor Sample Size Decisions. *The Accounting Review*, 65(1), 209-226. <https://doi.org/10.2308/TAR-9603274039>
- Kamau, C. G., & Kariuku, S. (2012). Factors Influencing Sample Size for Internal Audit Evidence Collection in the Public Sector in Kenya. *International Journal of Advances in Management and Economics*, 1(2), 42-49. <https://doi.org/10.31270/ijame/01/02/2012/05>
- Menzefricke, U., & Smieliauskas, W. (1988). On Sample Size Allocation in Auditing. *Contemporary Accounting Research*, 4(2), 314-336.  
<https://doi.org/10.1111/j.1911-3846.1988.tb00669.x>
- Patterson, E. R. (1993). Strategic Sample Size Choice in Auditing. *Journal of Accounting Research*, 31(2), 272-293. <https://doi.org/10.2307/2491274>
- Tarkh, A. S., Al-Jumaili, H. N., & Thabit, T. H. (2024). The Effect of Quantitative Measurement of Risks of Material Misstatement on the Efficiency of Determining Audit Sample Sizes: An Applied Study. *Scientific Research Journal of Economics and Business Management*, 4(1), 1-15. <https://doi.org/10.47310/srjebm.2024.v04i01.002>